



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/66

Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар зөвлөмжийн дагуу “4 дүгээр Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ӨВАХУСЗДТГ/202101004” тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул тендерийг тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Э.Нямдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ